



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2015.03.19 № 02/2014  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Д.ГАНБАТ ТАНАА

Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д заасны дагуу албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын 2014 оны мэдүүлгийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан, мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайлангийн нэгдсэн дүнгийн тухай мэдээллийг хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДЭД ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



008169

**НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ 2014 ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН  
МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ШИНЭЧЛЭН  
БҮРТГЭСЭН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2015.03.19

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 113 байгууллагаас мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2014 оны тайлан мэдээг авч нэгтгэлээ.

2014 оны бүрдүүлэлтээр төрийн болон нутгийн захиргааны төв 112 байгууллага байсан бол 2015 онд Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Цөмийн энергийн газар, Усны үндэсний хороо, Газрын шинэтгэлийн үндэсний хороо хасагдаж, Аж үйлдвэрийн яам, Тахарын ерөнхий газар, Хөрөнгө оруулалтын газар, Эрдэнэс Монгол ХХК, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл, Төрийн орон сууцны корпораци ТӨУҮГ зэрэг 6 байгууллага нэмэгдсэн.

Авлигатай тэмцэх газарт 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлбэл зохих 270 мэдүүлэг гаргагчийн 268 нь хуульд заасан хугацаандаа мэдүүлсэн. 2015 онд шинээр 35 албан тушаалтан шинээр томилогдсон.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв 113 байгууллагын мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2015 оны тайлан /ХАСХОМ 1,2, 3 болон бичмэл тайлан/ мэдээг цаасаар болон цахим хэлбэрээр гаргуулан авч нэгтгэхэд улсын хэмжээнд **38423** мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс **38422** мэдүүлэг гаргагч буюу **99,99** хувь нь бүртгүүлсэн. Үүнээс хуульд заасан хугацаандаа 38421 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн бол 1 мэдүүлэг гаргагч /МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүн Б.Цэнддоо/ хугацаа хожимдуулсан, 1 мэдүүлэг гаргагч /МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүн Д.Сосорбарам/ мэдүүлгээ гаргаж өгөхөөс татгалзсан.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 20 дугаар тогтоолоор "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт"-ыг шинэчлэн баталж, төрийн захиргааны болон улс төрийн, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтнуудаас зарим мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлэхгүй болсон буюу 2014 онд 51854 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж бүртгэгдсэнээс 2015 онд мэдүүлэг гаргагчдын тоо **13161**-ээр хассагдсан.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд бүтэц, зохион байгуулалт нь улсын нууцийн зэрэглэлд хамаардаг төрийн тусгай 5 байгууллага болох Батлан хамгаалах яамны 278, Тагнуулын ерөнхий газрын 739, Хил хамгаалах ерөнхий газрын 653, Тахарын ерөнхий газрын 10, Зэвсэгт хүчний жанжин штабын 1372 болон төрийн өмчит хуулийн этгээд /гадаад/-ийн 28, нийт **3080** мэдүүлэг гаргагч бүртгэгдээгүй буюу цаасан хэлбэрээр бүртгүүлсэн.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн нэгдсэн тайлангаар хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлтийн талаар мэдүүлсэн 1648, ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл гаргасан 18225, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргасан 184, хувийн ашиг

сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргасан 13226, давхар ажил эрхлэлтийн талаар танилцуулсан 120, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдээлсэн 26 албан тушаалтан байна.

2014 оны мэдүүлгээ шинэчлэн гаргасан мэдүүлэг гаргагчид нь дараах ангилал зэрэглэлийн албан тушаалтнууд байна. Үүнд:

Үзүүлэлт	ТЗ	ТГ	УТ	ТҮ	ТӨХЭ	ТББ	ТӨАТ	Бусад	Нийт
Тоо	11548	11273	7686	4237	2258	45	243	1133	38423
Хувь	30,05%	29,34%	20%	11,03%	5,88%	0,12%	0,63%	2,95%	100%

Нийт мэдүүлэг гаргагчийн 15970 буюу 41,56 хувь нь Улаанбаатар хотод, 22453 буюу 58,44 хувь нь орон нутагт байна.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын судалгааг 2015 оны 03 дугаар 04-ний байдлаар нэгтгэн гаргалаа. Судалгаагаар **1671** эрх бүхий албан тушаалтан бүртгэгдсэн. Үүнээс төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв байгууллагын 113 байгууллагад **121** эрх бүхий албан тушаалтан, салбар нэгжийн байгууллагуудад **1550** эрх бүхий албан тушаалтан байна.

Нийт эрх бүхий албан тушаалтны 23 хувь нь нийслэлд, 77 хувь нь орон нутагт байна. Нийт эрх бүхий албан тушаалтнуудын **409** буюу **24.5** хувь нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс 2014 оны 12 дугаар сарын 31-ний хооронд шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтан байна.

Энэ жилийн мэдүүлгийн бүрдүүлэлтийн хувьд албан тушаалтнуудаас мэдүүлгийг цаасаар гаргуулж авахаас гадна цахим хэлбэрээр /3 дах удаа/ авч байгаа, мэдүүлэг гаргагчийн тоо урьд оноос 13161-ээр буюу 25,5 хувиар багассанаараа онцлогтой байна. Мөн мэдүүлэг гаргагчийн тоо цөөрсөн боловч 2014 оны сүүлээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбоотой зарим төрийн байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийгдэж, халаа сэлгээ ихээхэн гарсан нь бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд багагүй хүндрэл бэрхшээл үүсгэсэн.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР